



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 97

Номгон

Г

Эрдэнэцогт, Баянхонгор сумын хилийн цэсэд
өөрчлөлт оруулах, тодотгох талаар санал, дүгнэлт
гаргах ажлын хэсэг байгуулах тухай

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 75 дугаар зарлигаар батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хилийн цэсээр Эрдэнэцогт сумын нутагт байгаа “Шаргалжуут” орчмын газрын хилийн цэсэд өөрчлөлт оруулах саналыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн. Мөн саналд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Элбэнхийн 5 дугаар багийг татан буулгаж, Баянхонгор сумын 8 дугаар баг үүсгэсэн ч хилийн цэсийн асуудал нь Монгол Улсын Их Хурлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, Засгийн газрын 2008 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 6 хэсгийн 6.1, 17.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрдэнэцогт, Баянхонгор сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах, тодотгох талаар санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Батжаргал-Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: А.Цэцэнбилэг-Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүдэд: Т.Эрдэнэбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч

Ж.Мөнхсоёл-Баянхонгор сумын Засаг дарга

Ц.Төмөрбаатар-Эрдэнэцогт сумын Засаг дарга

Э.Энхбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Л.Баасанбат-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

Холбогдох сумдын багийн Засаг дарга, газрын даамлууд

Иргэний төлөөлөл

1190148

D:/2019/Alban bichig/th togtool-2019

2. Хилийн цэсэд өөрчлөлт оруулах талаар холбогдох хууль, журам зааврын дагуу сумдын багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн санал авах ажлыг зохион байгуулж 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор ажлын хэсгийн дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

